



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Данснаас хасагдсан хөрөнгийн
хөдөлгөөний төвийг татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Удирдлагын зөвлөлийн 2021 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, дүн шинжилгээ хийхэд тус төвийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг борлуулалтын орлогоос санхүүжүүлэхээр зохицуулсан байх боловч борлуулалтын орлого нь актлагдсан эд хөрөнгийг татан төвлөрүүлэх болон бусад урсгал зардлыг нөхөж чадахгүй байгаа буюу эдийн засгийн хувьд үр өгөөж муу, өндөр алдагдалтай байх тул Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийг 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2. Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төв татан буугдсантай холбогдуулан цаашид тус төвийн чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлэх тухай чиглэлийг холбогдох байгууллагуудад мэдэгдэн ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс (С.Сэржжаргал)-т үүрэг болгосугай.

3. Эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай 2021 оны 68 тушаалын хэрэгжилтийг хангах, татан төвлөрүүлсэн актлагдсан хөрөнгийг худалдан борлуулах, устгах, тус төвийн хашааг цэвэрлэх ажлыг зохион байгуулахыг Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийн менежер (Д.Энхбаатар)-т үүрэг болгосугай.

4. Тус төвийн ажилтан, албан хаагчдын ажлыг зохих журмын дагуу актаар хүлээлцэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс (А.Мөнгөн), холбогдох тооцоог хийж дуусгахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Уранчимэг) нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА

Тушаал2021



115050000131